



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

дод оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

“Авлигагүй Багахангай” уралдааныг
шалгаруулж, шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүй шударга байдлыг уриалсан “Авлигагүй Багахангай” уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг дүгнэж, шалгарсан бүтээлийг удирдамжийн дагуу дүүргийн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах, олон нийтэд сурталчлан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

2.Уралдааны шагналд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 500.000 (таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 09 -ны өдрийн 1711/24 дугаар
захирамжийн хавсралт



АВЛИГЫН ЭРСДЭЛЭЭС АНГИД БАЙХ, ЁС ЗҮЙ, ШУДАРГА БАЙДЛЫГ
УРИАЛСАН “АВЛИГАГҮЙ БАГАХАНГАЙ” ВИДЕО КОНТЕНТ, ПОСТЕР
ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ ШАГНАЛЫН ТӨСӨВ

Д/д	Төрөл		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүр зардал	Нийт зардал
1.	Видео контент (шагнал)	1-р байр	хүн	1	300.000	300.000
2.	Постер (шагнал)	1-р байр	хүн	1	150.000	150.000
3.	Өргөмжлөл		ш	1	50.000	50.000
Нийт дүн						500.000